


## Монгол Улс

### Судалгааны тухай


Засгийн газрын төсвийн талаарх шийдвэрүүд тухайлбал, ямар татвар ногдуулах, төрийн ямар үйлчилгээ үзүүлэх, өрийн хэмжээ хэд байх зэрэг нь нийгэм дэх бүх хүнд чухал үр дагавартай. Засгийн газар эдгээр шийдвэр гаргалтад шаардагдах мэдээллийг олон нийтэд түгээж, тэдгээрийн зүгээс оролцох боломжийг хангах бодит сувгуудыг бүрдүүлснээр нийтийн мөнгийг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн зарцуулж буйг баталгаажуулах илүү боломжтой болно.

#### Тойм




Ил тод байдал:

**64** / 100



Олон нийтийн  
оролцоо:

**35** / 100



Төсвийн хяналт:

**74** / 100

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгууруудыг ашигладаг хараат бус, харьцуулсан болон нотлох баримтад суурилсан дэлхийн цорын ганц судалгааны арга хэрэгсэл юм. Тухайлбал, засгийн газрын төсвийн мэдээллийг олон нийт авах боломж, улсын төсвийн үйл явцад олон нийтийн зүгээс оролцох албан ёсны боломжит сувгууд, мөн хууль тогтоох болон аудитын байгууллага зэрэг төсвийн хяналтын институциуд төсвийн үйл явцыг хянахад гүйцэтгэж буй үүргийг үнэлэх шалгууруудад тулгуурлан хийгддэг.

Уг судалгаа нь тухайн улсын иргэний нийгэмд өөрийн улсын засгийн газартай нийтийн хөрөнгийн ашиглалт болон энэ талаар өгч буй мэдээлэлд үнэлгээ өгч, зөвлөлдөхөд туслах зорилготой юм. Төсвийн нээлттэй байдлын судалгааны энэхүү 10 дахь хэвлэл нь дэлхийн 82 орныг хамарсан болно.

[www.internationalbudget.org/open-budget-survey](http://www.internationalbudget.org/open-budget-survey) цахим хуудаснаас судалгааны бүрэн аргачлал, судалгаанд хамрагдсан улс орнуудын дүн, өгөгдлийн сан зэрэг илүү дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.


### Төсвийн ил тод байдал

Төсвийн нээлттэй байдлын судалгааны энэ хэсэгт төв засгийн газар орлогоо хэрхэн бүрдүүлж, нийтийн хөрөнгийг хэрхэн зарцуулдаг талаар олон нийт мэдээлэл авах боломжийг хэмжинэ. Энэ хэсэгт төсвийн 8 үндсэн баримт бичгийн цахим хэлбэрээр, цаг хугацаандаа нийтлэгддэг, иж бүрэн эсэхийг 109 ижил жин бүхий үзүүлэлтээр хэмжиж, улс бүрийг 0-ээс 100 хүртэлх оноогоор үнэлнэ. Төсвийн ил тод байдлын 61 болон түүнээс дээш оноо нь тухайн улс төсвийн хангалттай хэмжээний мэдээллийг ил болгож буй бөгөөд энэ мэдээлэл төсвийн ач холбогдол бүхий гол өгөгдлүүдийг хамарч, засгийн газраас төсвийн


чиглэлээр гаргаж буй шийдвэрүүдийг олон нийт ойлгох боломжийг бий болгож, иргэд төсвийн бодлогын хэлэлцүүлэг, мэтгэлцээнд мэдээлэлтэйгээр оролцоход дэмжлэг болж байгааг илтгэнэ.

Монгол Улсын төсвийн ил тод байдлын оноо авбал зохих 100 онооноос **64** байна.

## Монгол Улсын төсвийн ил тод байдал бусад оронтой харьцуулахад



## Монгол Улсын төсвийн ил тод байдал, 2015-2025 он



## Монгол Улсын төсвийн баримт бичгийн олон нийтэд нээлттэй байдал

**ТЭМДЭГЛЭГЭЭ**

- Олон нийтэд нээлттэй
- Хугацаа хэтэрч нийтэлдэг, эсвэл цахимаар нийтэлдэггүй, эсвэл зөвхөн дотоод хэрэгцээнд зориулан боловсруулдаг
- ⊘ Боловсруулдаггүй

Баримт бичиг	2015	2017	2019	2021	2023	2025
Төсвийн хүрээний мэдэгдэл	●	●	●	●	●	●
Засгийн газрын төсвийн төсөл	●	●	●	●	●	●
Батлагдсан төсөв	●	●	●	●	●	●
Иргэдийн төсөв	●	⊘	●	●	●	●
Явцын гүйцэтгэлийн тайлан	●	●	●	●	●	●
Хагас жилийн тайлан	⊘	●	⊘	⊘	●	●
Жилийн эцсийн тайлан	●	●	●	●	●	●
Аудитын тайлан	●	●	●	●	●	●

# Монгол Улсын олон нийтэд нээлттэй төсвийн баримт бичгийн агуулгын иж бүрэн байдал

## ТЭМДЭГЛЭГЭЭ

- **61-100 / 100:**  
Олон нийтэд нээлттэй
- **41-60 / 100:**  
Хязгаарлагдмал
- **1-40 / 100:**  
Сүл

Төсвийн үндсэн баримт бичиг	Баримт бичгийн зорилго ба агуулга	Үнэлгээ хийсэн төсвийн жил	Баримт бичгийн агуулгын оноо
Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөл боловсруулахаас өмнө Засгийн газрын төсөв санхүүгийн бодлогын ерөнхий үзүүлэлтийг мэдээлнэ; Засгийн газрын эдийн засгийн талаарх төсөөлөл, хүлээгдэж буй орлого, зарлага, өрийн талаарх тоймыг гаргана.	2025	78
Засгийн газрын төсвийн төсөл	Засгийн газраас хууль тогтоох байгуулагад батлуулахаар өргөн барина; төсвийн орлогын эх үүсвэр, яамдад олгох төсвийн хуваарилалт, санал болгож буй бодлогын өөрчлөлтүүд болон тухайн улсын төсвийн байдлыг ойлгоход шаардлагатай бусад чухал мэдээллийг нарийвчилж өгнө.	2025	62
Батлагдсан төсөв	Хууль тогтоох байгууллагаас баталсан төсөв юм.	2025	39
Иргэдийн төсөв	Засгийн газрын төсвийн төсөл эсвэл батлагдсан төсвийн энгийн, хялбаршуулсан хувилбар, олон нийтэд төсвийн талаар чухал мэдээлэл хүргэх зорилготой.	2025	75
Явцын тайлан	Төсвийн төвлөрүүлсэн орлого, гарсан зарлага, хуримтлагдсан өрийн бодит гүйцэтгэлийн талаарх тодорхой цаг хугацааны давтамжтай гардаг мэдээллийг багтаана; улирал эсвэл сараар гаргана.	2024	96
Хагас жилийн тайлан	Төсвийн хэрэгжилтийн талаарх төсвийн жилийн хагасаар гаргах дэлгэрэнгүй мэдээлэл; төсөв боловсруулахад ашигласан эдийн засгийн урьдчилсан нөхцөлийг нягталж, төсвийн хүлээгдэж буй үр дүнгийн талаарх шинэчилсэн таамаглалыг багтаана.	2024	26
Жилийн эцсийн тайлан	Төсвийн жилийн эцэс дэх засгийн газрын данс, санхүүгийн байдлыг тайлбарлана, мөн төсвийн жилд тавьсан бодлогын зорилтын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшлийн талаарх үнэлгээг оруулбал нэн сайн.	2023	82
Аудитын тайлан	Аудитын дээд байгууллага гаргана. Энэ тайлан нь засгийн газрын жилийн эцсийн данс, санхүүгийн тайлан үнэн зөв бөгөөд иж бүрэн эсэхийг дүгнэнэ.	2023	62

Монгол Улсын 2053 оны төсвийн ил тод байдлын оноо **64** буюу 2023 оны үзүүлэлттэй ойролцоо байна.

## Зөвлөмж

Төсвийн ил тод байдлыг сайжруулахын тулд Монгол Улс дараах арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай:

- Гүйцэтгэх засаглалын Төсвийн саналд олон жилийн илүү цогц төсөөлөл (төсвийн жилээс хойш наад зах нь хоёр жилийн тооцоог багтаасан) болон макро эдийн засгийн урьдчилсан байдлын мэдээллийг тусгах бөгөөд үүний тулд мэдрэмжийн шинжилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, олон жилийн зарлагын төсөөлөл, олон жилийн орлогын төсөөлөл, мөн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлын талаарх мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх;
- Батлагдсан төсвийг өргөжүүлж, орлогын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг тусгах бөгөөд үүний тулд орлогын ангиллыг (татварын болон татварын бус) тодорхой харуулж, тус бүрийн орлогын эх үүсвэрийн задаргаатай мэдээллийг танилцуулах.
- Батлагдсан Төсвийн баримт бичигт зардлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг иж бүрэн эдийн засгийн ангилал болон зориулалтын ангиллаар тусгах.
- Жилийн эцсийн Тайланд макро эдийн засгийн урьдчилсан мэдээллийн илүү цогц өгөгдөл болон өрийн мэдээллийг тусгах бөгөөд үүний тулд анхны макро эдийн засгийн урьдчилсан таамаглал болон бодит үр дүнгийн хоорондох харьцуулалт, мөн зээлийн урьдчилсан тооцоо болон бодит үр дүнгийн хоорондох харьцуулалтын ил тод байдлыг сайжруулах.
- Төсвийн хагас жилийн тайлангийн иж бүрэн байдлыг сайжруулах бөгөөд үүний тулд хөтөлбөрийн түвшний зардлын дэлгэрэнгүй мэдээлэл, зардлын ангиллын дэлгэрэнгүй мэдээлэл, орлогын ангиллын (татварын болон татварын бус) мэдээлэл, мөн орлогын тус бүрийн эх үүсвэрийн талаарх мэдээллийн ил тод байдлыг бэхжүүлэх.


## Иргэдийн оролцоо

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь засгийн газрууд төсвийн үйл явцын янз бүрийн үе шатанд олон нийтийн оролцооны албан ёсны болон утга учир бүхий боломжийг хэр хэмжээгээр олгож байгааг үнэлдэг. Энэхүү үнэлгээ нь иргэдийн оролцоо нь өөр өөр байгууллагуудад явагдаж болохыг хүлээн зөвшөөрч, төв засгийн газрын гүйцэтгэх байгууллага (яамдыг оролцуулан), хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллага (АДБ)-ын ашигладаг оролцооны практикийг судалдаг.

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь 18 тэнцүү жинтэй үзүүлэлтийг ашиглан эдгээр оролцооны механизмүүд нь Global Initiative for Fiscal Transparency буюу Төсвийн бодлогын ил тод байдлын дэлхийн санаачилга (GIFT)-ын **Principles of Public Participation in Fiscal Policies** (Төсвийн бодлогод олон нийтийн оролцооны зарчмууд)-тай нийцүүлэн цаг тухайд нь, тэгш хамруулан оролцуулсан, ил тод болон хариуцлагатай эсэхийг үнэлдэг. Төрийн байгууллагууд төсвийн үйл явц бүрд албан ёсны олон нийтийн оролцоог хангаж буй практикийн түвшнээр үлс бүрийг 0-ээс 100 хүртэлх оноогоор дүгнэдэг.

Монгол Улсын олон нийтийн оролцооны оноо авбал зохих 100 онооноос **35** байна.

## Монгол Улсын олон нийтийн оролцоо бусад оронтой харьцуулахад:



Олон нийтийн оролцооны шинэлэг арга барилын талаарх дэлхийн сайн туршлагын талаар <https://www.fiscaltransparency.net/case-studies/> цахим холбоосноос үзнэ үү.

## Төсвийн үйл явцад олон нийт оролцох боломж



## Зөвлөмж

Монгол Улсын Сангийн яам нь олон нийттэй төсөв боловсруулах үе шатанд цахимаар, төсвийн гүйцэтгэлийн үе шатанд онлайн платформ болон цахимаар тус тус зөвлөлдөх механизмыг нэвтрүүлсэн боловч төсвийн үйл явц дахь нийтийн оролцоог цаашид бэхжүүлэхийн тулд дараах арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай:

- Оролцохыг хүссэн иргэний нийгмийн байгууллага болон олон нийтийн аль ч гишүүнийг хамруулах үүднээс төсөв боловсруулах үе шат дахь оролцооны механизмуудыг өргөжүүлэх.
- Төлөөлөл багатай нийгмийн бүлгүүдтэй шууд буюу тэдгээрийг төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан идэвхтэй хамтран ажиллах.
- Төсөв боловсруулах болон гүйцэтгэх үе шатанд хүлээн авсан олон нийтийн саналуудын дэлгэрэнгүй баримт бичгийг боловсруулж нийтэд нээлттэй болгох бөгөөд үүнд ирүүлсэн санал хүсэлтийн хураангуй болон уг оролцоог шийдвэр гаргах үйл явцад хэрхэн харгалзан үзсэн буюу ашигласан талаарх тайлбарыг тусгаж, ил тод байдлыг нэмэгдүүлж, олон нийтийн оролцооны үр нөлөөг харуулах.

Монгол Улсын Улсын Их Хурал жилийн төсвийг батлахтай холбогдуулан салбарын сонсгол болон цахим саналын механизмыг нэвтрүүлсэн боловч дараах арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай:

- Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аливаа төлөөлөгч төсөв батлагдахаас өмнөх хэлэлцүүлгийн үеэр сонсголд оролцож мэдүүлэг өгөх боломж бүрдүүлэх.
- Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аливаа төлөөлөгч аудитын тайлан хэлэлцүүлгийн үеэр сонсголд оролцож мэдүүлэг өгөх боломж бүрдүүлэх.

Үндэсний аудитын газар нь аудитын хөтөлбөр боловсруулахад иргэдийг оролцуулах механизмыг бий болгосон байна. Цаашид төсвийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авах шаардлагатай:

- Холбогдох аудитын шалгалт хийх үйл явцад олон нийт хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бий болгох.

## Төсвийн хяналт

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллагууд (АДБ) төсвийн үйл явцад хяналт тавихад гүйцэтгэх үүргийг судалдаг бөгөөд үүнд төсвийн саналуудыг хэр үр дүнтэй шалгаж байгаа, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж байгаа болон засгийн газрын тайланг хянан үзэж байгаа эсэхийг хамруулан авч үздэг. Төсвийн нээлттэй байдлын судалгаа 18 тэнцүү жинтэй үзүүлэлтийг ашиглан эдгээр хяналтын байгууллагын хүч чадал болон хараат бус байдлыг үнэлж, тус бүр үлсыг 0-ээс 100 хүртэлх оноогоор үнэлдэг.


Үүнээс гадна, судалгаагаар төсвийн бодлогын талаарх мэдлэгт суурилсан хэлэлцүүлэг болон хяналтыг сайжруулахад хувь нэмэр оруулж чадах хараат бус төсвийн байгууллага(ХБТБ) байгаа эсэх болон түүний үүргийн талаарх нэмэлт мэдээллийг цуглуулдаг (доорх Шигтгээ хэсгийг үзнэ үү).

Монгол Улсын хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллага хамтран төсвийн үйл явцыг хангалттай түвшинд хянадаг бөгөөд төсвийн хяналтын нийлмэл оноо авбал зохих 100 онооноос **74** байна. Хоёр байгууллагын хяналтыг тус бүрээр нь доорх зурагт үзүүлэв.

### Хууль тогтоох байгууллагын хяналт



### Аудитын хяналт



ТЭМДЭГЛЭГЭЭ



0 - 40: Сул



41 - 60: Хязгаарлагдмал



61 - 100: Хангалттай

## Зөвлөмж

Улсын Их Хурал төсвийн төлөвлөлтийн үед хангалттай түвшний хяналт тавьдаг хэдий ч төсвийн гүйцэтгэлийн үе шат дахь хяналт хязгаарлагдмал байна. Хяналтыг цаашид сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг чухалчлан авч үзэх шаардлагатай:

- Хууль тогтоох байгууллагын байнгын хорооноос төсвийн гүйцэтгэлийн жилийн явцын тайланг хэлэлцэж, гарсан дүгнэлтийг цахимаар нийтэлж байх.
- Төсвийн жилийн дундуур төсвийн хөрөнгийн хуваарилалтыг захиргааны нэгжүүдийн хооронд шилжүүлэх тохиолдолд хууль тогтоох байгууллагатай зайлшгүй зөвшилцдөг байх.
- Хууль тогтоох байгууллагын байнгын хорооноос төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж, гарсан дүгнэлтийг цахимаар нийтэлж байх.

### **Шигтгээ: Төсвийн хараат бус байгууллагыг үүсгэн байгуулахын ач холбогдол**

Монгол Улс Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэмээх төсвийн хараат бус байгууллагатай. Зөвлөлийн хараат бус байдлыг хуулиар тогтоосон бөгөөд зөвлөл нь хууль тогтоох байгууллагад тайлагнадаг.

Тус байгууллага нь өөрийн макро эдийн засгийн болон төсвийн таамаглалыг нийтэлдэг; гэхдээ шинэ бодлогын саналуудын өртгийн үнэлгээг нийтэлдэггүй.

*Төсвийн хараат бус байгууллагын үзүүлэлтийг Төсвийн нээлттэй байдлын судалгааны оноо тооцоход оруулаагүй болно.*

## Аргачлал

2025 оны Төсвийн нээлттэй байдлын судалгааг зөвхөн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал олон нийтэд зориулан нийтэлсэн баримт бичиг, болж өнгөрсөн үйл явдал, өрнөсөн үйл ажиллагаа болон гарсан өөрчлөлтүүдэд суурилан гаргав.

Энэхүү судалгаа нь бүх улсын хувьд төсвийн хараат бус шинжээчдийн бөглөсөн асуулгад суурилдаг болно. Монгол Улсын хувьд уг судалгааны шинжээчид:

Даваахүүгийн Оюунбадам, Чулуунхүүгийн Нарантуяа

Нээлттэй Нийгэм Форум ([www.forum.mn](http://www.forum.mn))

[oyunbadam@forum.mn](mailto:oyunbadam@forum.mn)

Судалгааг улам чанаржуулах зорилгоор Монгол Улсын бөглөсөн асуулгын эхний хувийг тус улсын Сангийн яамны төлөөлөгч нягталдаг.